



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/112

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх  
 тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 1 дүгээр баг, 3 дугаар сургуулийн урд талд байршилтай, иргэн Их монгол овогт Сандагийн Эрдэнэчимэгийн үйлчилгээний зориулалттай 900 м2 газрыг “Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ”-ний дагуу иргэн Боржигон овогт Пүрэвсүрэнгийн Түвшинтогтоход “Үйлчилгээ”-ний зориулалтаар, тус 900 м2 газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмшигч иргэн (Пүрэвсүрэнгийн Түвшинтогтох)-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмшигч иргэн Пүрэвсүрэнгийн Түвшинтогтохтой газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Э.Баярмагнай)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны А/112 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ